

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГАТАЙ 2018 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ  
ТАЛААР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2018.06.20

№	Хийж гүйцэтгэх ажил	Хэрэгжилт	Хувь
<b>Нэг. Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэлийн чиглэлээр</b>			
1.1	Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх	<p>Шинээр батлагдсан Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуулиудыг сурталчлах зорилготой сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, хэлтэс, агентлагийн дарга, орлогч, тасгийн дарга, ахлах мэргэжилтэн, хүний нөөц, дотоод ажил, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд, сумдын ЕБС-ийн захирал, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн дарга, эрхлэгч нар, Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд нийт 350 орчим албан хаагчдыг хамруулан Төсвийн сахилга хариуцлагын талаарх Аудитын газрын мэдээлэл; Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах асуудал; Төрийн албан хаагчийн баримтлах зарчим, ёс зүйн тухайд; Төрийн албаны хуулийн шинэчлэл, үзэл баримтлал; Захиргааны ерөнхий хууль, захиргааны хэм хэмжээний акт; Албан хэрэг хөтлөлт, анхаарах асуудал; Удирдлагын зарим нэр төрлийн баримт бичгийг боловсруулж бүрдүүлэх нь зэрэг сэдвүүдээр зохион байгуулав. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан “Гэрч, хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж буй аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв, Хэвлэл мэдээллийн төлөөлөл, Прокурор, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Оюуны гэгээ ТББ зэрэг байгууллагуудтай хамтран “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, үйл ажиллагааны уялдаа, холбоо, хамтын ажиллагаагаа сайжруулах, анхаарч ажиллахаар болов. Мөн Хөдөлмөрийн тухай хуулиар 3 сумын иргэд, албан хаагчдын дунд ярилцлага зохион байгуулж, гарсан саналыг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. 2018 онд</p>  	100%

		Аюулаас сэргийлэх цогцолбор FM107.5 радиогоор “Хуулийн цаг”, “Мэдээллийн цаг”-аар “Малын генетик нөөцийн тухай”, “Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Авлигын эсрэг хууль”, “Ашиг сонирхлын зөрчил, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт”, “Зөрчлийн тухай хуулийн зорилго, үзэл баримтлал, хугацааны талаар”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”, “Төрийн албан хаагчийн манайлал” аймгийн зөвлөгөөн, “Хүүхэд-Хэрэглэгч” аяны талаар тус тус мэдээлэл хийж ажиллалаа. Сайнцагаан сумын ЗДТГ-тай хамтран “Сайнцагаан-Сүүн Сайнцагаан” орон нутгийн сонинд “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийндаатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”-ийг иргэдэд таниулах, зорилгоор нийтлүүлж сурталчилсан.	
1.2	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, баг, хороо, сумдын эрх зүйн сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүдэд Хууль зүйн яам /хуучнаар/-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 онд баталсан “Эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачилсан зөвлөмж”-ийг таниулах, хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах	Тус аймгийн сумдад эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан тусдаа орон тоо байдаггүй. Сумдад 2009 оноос иргэд, олон нийтэд хууль тогтоомж сурталчлах чиг үүрэг бүхий сумдын ЗДТГ-ын даргаар ахлуулсан “Эрх зүйн хөтөч” орон тооны бус баг байгуулж, жил бүр арга зүйгээр хангах сургалтыг багийн ахлагч нарын сургалтаар жил бүр зохион байгуулж хэвшсэн. 2018 оны 5 дугаар сард “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээлэл бэлтгэх, түүнийг түгээх талаар гаргасан аргачилсан зөвлөмж”-өөр сургалт зохион байгууллаа.	 <p>70%</p>
1.3	Шинээр батлагдсан хууль тогтоомжийн агуулгаар иргэдэд зориулсан хялбаршуулсан нугалбар хуудас бэлтгэж, түгээх	Аймгийн Засаг даргын “Иргэдээ сонсьё” төрийн үйлчилгээний нэгдсэн өдөрлөгөөр Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Гурвансайхан сумдын төрийн байгууллагын албан хаагчид болон иргэдэд шинээр батлагдсан хууль тогтоомжуудоор эрх зүйн сургалтыг зохион байгуулж, заагдсан сэдэв бүрээр гарын авлага материалыг тарааж ажиллалаа. Мөн Ашиг сонирхлын зөрчлийн талаар гаргах мэдэгдэл тайлбар гаргах, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжоор иргэдэд зориулсан гарын авлага материалуудыг 15 сум, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудад 1282 ширхэгийг тарааж ажилласан. Шинээр болон шинэчлэн найруулгаар батлагдан гарсан Төрийн албаны тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Донорын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай гэх мэт хууль тогтоомжуудыг ABLE программын олон нийт цэсийн файлын санд эрх зүйн актын мэдээлэл нэртэйгээр байршуулж бусад хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн хамт бэлтгэж тогтмол сурталчилж ажиллалаа.	 <p>100%</p>

1.4	Аймгийн хэмжээнд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн хөтөлбөр, удирдамжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах	Аймгийн хэмжээнд зохион байгуулах сургалт, сурталчилгааг тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу сум, байгууллага, иргэдийн санал хүсэлтээр эрх зүйн албан ба албан бус сургалтыг 8 удаа, сурталчилгаа 3 удаа, хэлэлцүүлэг 2 удаа тус тус мэргэжлийн байгууллагуудтай хамтран 800 гаруй иргэд, албан хаагчдад зохион байгуулж, зөвлөгөө, лавлагаа, баримт бичиг боловсруулах чиглэлээр 23 иргэнд эрх зүйн туслалцаа үйлчилгээг үзүүллээ. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөр, “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч/сумдын ЗДТГ-ын дарга/ нарын үйл ажиллагааг эрчимжүүлж чадавхжуулах чиглэлээр эрх зүйн сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшүүллээ. Тус оны “Эрх зүйн хөтөч” багийн ахлагч буюу сумын ЗДТГ-ын дарга нарыг чадавхжуулах сургалтыг өргөжүүлэн 2018 оны 5 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд Төрийн албан хаагчийн хандлага, харилцааны соёл; Бүх шатны төсвийн захирагч, санхүү бүртгэлийн ажилтны сахилга хариуцлага, манлайлал; Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, өөрчлөлт /Малчин даатгуулагчийн, өндөр насны тэтгэвэр тэтгэмжийн тухай/”; Эрүүл зан үйлийг дэмжсэн “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөр төслөөр; “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөр; Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, тайлан мэдээ гаргахад анхаарах асуудал; Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг яаж бүрдүүлэх, хяналтын дагалдах хуудсыг бий болгох зэрэг сэдвүүдээр тус тус зохион байгууллаа. Сургалтын явцад малчны тэтгэврийн талаар сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нараар ахлуулсан зөвлөлийн үйл ажиллагааны талаар Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтарсан уулзалт ярилцлага зохион байгуулж, асуулт хариулт явагдлаа. Сургалтын төгсгөлд Эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааны 2017 оны тайланг үнэлсэн үнэлгээг танилцуулан, цаг үеийн болоод хамтран ажиллах талаар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга санал солилцож, сургалтын үйл ажиллагааг дүгнэлээ.	70%
1.5	Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал, агуулга, ач холбогдлыг байгууллага, албан тушаалтанд сурталчлах, тэдэнд мэдлэг олгоход чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Сумдын Засаг дарга нараас батлан гаргасан болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нараас батлан гаргасан эрх зүйн актуудыг эрх зүйн актыг Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянах хуваарийг хэлтсийн дарга болон ЗДТГ-ын дарга батлан хэрэгжүүлж байна. 2018 оны 1 дүгээр улиралд сумдын Засаг дарга нарын батлан гаргасан нийт 325 эрх зүйн акт, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга болон түүний харьяа байгууллагуудын дарга нараас батлан гаргасан нийт 155 эрх зүйн акт, аймгийн Засаг даргын харьяа 9 агентлагийн дарга нарын батлан гаргасан нийт 295 эрх зүйн актыг хууль зүйн үндэслэлийг хянаж, гарсан зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлж Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхэд сум, байгууллагуудын удирдлага, төрийн албан хаагчдад чиглэл, зөвлөгөөг тухай бүр өгч байна. Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаар сум, байгууллагуудад удирдлага арга зүйгээр хангаж, олон нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр боловсруулах, батлахдаа иргэдийн саналыг авч, хэлэлцүүлдэг байх талаар заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьж	70%

		ажиллаж байна.	
1.6	“E-Khutuch” эрх зүйн туслалцааны цахим хуудсаар иргэдийн эрх зүйн харилцааны чадамжийг дээшлүүлэх төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн орон нутагт хэрэгжиж буй эрх зүйн акт, төсөл, хөтөлбөр тухайн орон нутгийн төрийн байгууллагаас нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг бэлтгэн Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлж, тэдгээрийг хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан тохиолдолд цаг тухайд нь мэдээлэх	“E-Khutuch” эрх зүйн туслалцааны цахимд оруулах орон нутагт хэрэгжиж буй эрх зүйн акт, төсөл, хөтөлбөр, төрийн байгууллагаас нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн хавсралт 5 хүснэгтийн дагуу бэлтгэн гаргаж тус хүрээлэнгийн холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. АБЛЕ програмд Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэн хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт, хүчингүй болгосон эрх зүйн акт болон бусад эрх зүйн актуудын талаарх мэдээллийг бэлтгэн тавьж төрийн албан хаагчдад сурталчилан ажиллаж байна.	70%
1.7	“E-Khutuch” цахим хуудсыг орон нутагт хариуцан ажиллах албан тушаалтныг тусгайлан томилж, ажил үүргийн тодорхойлолтод нь уг чиг үүргийг тусган Хууль зүйн үндэсний хүрээлэнд мэдээлж, хамтран ажиллах	Хууль, эрх зүйн хэлтсийн хүрээнд хэлэлцэж, уг хэлтсээстус ажлыг хариуцах ажилтныг томилон ажиллуулахаар чиг үүрэг буюу ажил үүргийн тодорхойлолт нь тусгаж, зохих дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.	100%
1.8	Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон болон тухай орон нутагт мөрдөх хэм хэмжээ тогтоосон болон тухайн орон нутагт мөрдөх шийдвэр, тогтоолыг агуулсан эмхэтгэл гаргаж сум, багийн Засаг дарга түүний ажлын албаны өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн Засаг даргаас 1-5 дугаар сар хүртэл батлан гаргасан захирамжуудаас 202 захирамжийг аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> вэб сайтын эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулан ажиллалаа. Мөн гэмт хэрэг, зөрчлийн мэдээг сар бүр аймгийн Засаг даргын шуурхайд мэдээлж байна. Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон болон тухайн нутаг дэвсгэрт мөрдөх шийдвэр, тогтоолыг агуулсан эмхэтгэлийн эхийг бэлтгэж байна. Тус оны 3 дугаар улирлаас гаргаж нийтлүүлэхээр бэлтгэл ажлыг хийж гүйцэтгээд байна.	30%
1.9	Холбогдох хуулиар тусгайлан эрх олгогдсоны дагуу захиргааны хэм хэмжээний эрх зүйн актыг	2018 онд Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны хэм хэмжээний эрх зүйн актын шинж агуулсан аймгийн Засаг даргын баталсан 1 шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан 1 шийдвэрийг тус тус Захиргааны ерөнхий хуулийн 60	70%

	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлснээр дагаж мөрдөх	дугаар зүйлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж холбогдох дүгнэлт, зөвлөмж авч хэрэгжүүлж байна. Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож олон нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр боловсруулах, батлахдаа иргэдийн саналыг авч, хэлэлцүүлэхийн зэрэгцээ захиргааны хэм хэмжээний эрх зүйн актыг ХЗДХЯ-нд хянуулж бүртгүүлснээр дагаж мөрдөх талаар сум, байгууллагуудад удирдлага арга зүй, заавар, зөвлөгөө өгч ажилласнаар сумдын ЗДТГ-аас тодорхой зөвлөгөө авах ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр хүргүүлэх зэргээр захиргааны хэм хэмжээний эрх зүйн актын талаарх ойлголт, мэдлэг нэмэгдэж байна.	
1.10	НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах	НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тогтоолыг хяналтанд авч холбогдох заалтыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: Шинээр батлагдсан хууль тогтоомжийг тухай бүр иргэд, байгууллагад сурталчлан ажиллах, хүүхдийн эрхийг хамгаалах талаар гэр бүлийн зөвлөл болон хүүхдийн хууль зүйн хороо, хамтарсан багууд олон талт арга хэмжээг зохион байгуулах, хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор урьд оны 10 дугаар сарын 1-нээс дараа оны 6 дугаар сарын 1 хүртэл хурдан морины уралдааныг зохион байгуулахгүй байх талаар шийдвэрийг гаргуулж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн уулзалтыг аймгийн удирдлагуудад хамтран зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар “Архидалтгүй аймаг-Дундговь” аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх зэрэг олон талт арга хэмжээнүүдийг тасралтгүй зохион байгуулж байна.	100%
<b>Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>			
2.1	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөө болон үр дүнг хагас, бүтэн жилээр 7 дугаар сарын 05, 12 дугаар сарын 15-ны дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнах	Аймгийн ГХУСАЗЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 бүлгийн 33 асуудалтай хэлэлцэн батлуулж, сум, байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд төлөвлөгөөний явцад хяналт тавин эрчимжүүлэн, зохион байгуулж буй ажлын мэдээг аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> , <a href="http://www.khural.mn">www.khural.mn</a> , ГХУСАЗСЗ-ийн <a href="http://www.cccp.mn">www.cccp.mn</a> сайтуудад тус тус байршуулан сурталчилж байна. Тус хугацаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар зөвлөлийн ээлжит хурлаар зөвлөлийн 2018 онд батлагдсан төлөвлөгөөнд нэмэлт тодотгох санал, аймгийн ГХУС-д олон талт хамтын ажиллагаа зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн дагуу хийх ажлыг төлөвлөгөөнд нэмж тусган хэрэгжүүлж байна.Тус салбар Зөвлөлөөс гэмт хэрэг зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Хуулиа мөрдье-21”, “Сэрэмжилье-нэгдье”, “Хуулийн хэрэгжилт”, “Сар шинэ”, “Хүүхдээ хамгаалъя” “Бяцхан зорчигч”, “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээнүүдболон 13 төрлийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулахад зохих дэмжлэг үзүүлж мэргэжлийн байгууллагуудтай	100%



		хамтран ажиллаж үр дүнг нь тооцож холбогдох газарт хүргүүлж ажилласан. Сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 15 сумын ИТХ-д 8.0 сая төгрөг олгохоор шийдвэрлэж, хагас жилийн байдлаар ажлын үр дүнг тооцон сумдад 6.0 сая төгрөгний санхүүжилтийг олгосон. Зөвлөлийн эхний хагас жилийн тайланг ХЗДХЯ-нд хугацаанд нь тайлагнахаар Зөвлөлийн гишүүн байгууллага, сумдын ГХУССЗ-өөс 2018 оны эхний хагас жилд зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэж байна.	
2.2	Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн бүтэц орон тооны асуудлыг шийдвэрлэх, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	Аймгийн Засаг даргын 2018 оны А/47 дугаар захирамжаар Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төвийн хамгаалах байрны 8 цонхонд дохиолол суулгаж, гал тогооны өрөөнд утаа мэдрэгч байршуулах зардал болон урсгал зардалд 1.8 сая төгрөг нийт 2.8 сая төгрөгийг шийдвэрлэж, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Хамгаалах байрны арга зүйчийг томилон байнгын ажиллуулж, цалин урамшуулал, хоол, чадваржуулах сургалтын томилолтын зардал зэрэгт 3.3 сая төгрөг зарцуулж хамгаалах байр тогтмол ажиллаж байна. Хамгаалах байрны бусад үйлчилгээ буюу сэтгэл зүйч, эмч, хууль зүйн үйлчилгээ зэргийг бусад мэргэжлийн байгууллагуудтай холбон зуучлах байдлаар нэг дороос үйлчилгээ үзүүлж хамтран ажиллаж байна.	100%
2.3	Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг санхүүжүүлэх	Аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүний эрхийн үндэсний комисс, Улаан загалмайн хороотой тус тус хамтран “Хамтын ажиллагаа” сургалтын арга хэмжээг 2018.02.06- ний өдөр зохион байгуулан явуулж аймгийн төв Сайнцагаан сумын 5 багийн 50 иргэнийг хамруулж, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүний эрх, Гэр бүлийн хүчирхийлэл, Анхны тусламж үйлчилгээний талаар сургалт мэдээлэл хийж, шаардлагатай нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүүхдийн эрх зөрчигдсэн гэх дуудлага мэдээлэл Цагдаагийн газрын жижүүрийн 7059102 дугаарын утсанд 8, 108 дугаарын утсанд 10 ирснийг цаг тухай бүрд нь хүлээн авч холбогдох журмын дагуу аюулын зэргийн үнэлгээг хийж хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3–д заасныг үндэслэн хамтарсан багт мэдэгдэж 8 кейсийг нээлгэж хамтарсан багийн хяналтанд өгч хамтран ажиллалаа.	70%
2.4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтныг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	Цагдаагийн газрын УСАХАМ цагдаагийн ахмад Н.Ганбат, аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн дарга Б.Түвшинбаяр, Эрүүл мэндийн газрын дарга Г.Бат-Орших, ХГБЗХГ-ын ахлах мэргэжилтэн Г.Энхбилгүүн нарыг Улаанбаатар хотод энэ оны 04 дүгээр сарын 11, 12 -ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” Үндэсний II чуулганд оролцуулсан. ЦГ-ын алба хаагчдын сургалт цугларалтаар “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авах ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулж, хэсгийн мөрдөгч нарт хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх таслан зогсоох урьдчилан сэргийлэх талаар 2 удаа зөвлөмж бичиж хүргүүлсэн. Сургалтын арга хэмжээнд 38 алба хаагч хамрагдсан. Аймгийн ГХУСАЗСЗөвлөл, Цагдаагийн газар, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Дэлхийн зөндүндговь” ОНХХ-тэй тус тус хамтран хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс	100%

		урьдчилан сэргийлэх, осол, хүчирхийлэлд өртсөн иргэд, хүүхдийн мэдээллийг хүлээн авч, шалган, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг ханган, нөхцөл байдлын үнэлгээ хийж, мэргэжлийн цогц үйлчилгээг багаар үзүүлэх чадвар эзэмшүүлэх зорилгоор сумдын хамтарсан багийн 154 гишүүнийг хамруулан 04 дүгээр сарын 09-13, 24-27-ны өдрүүдэд лекц, бүлгийн ажил, хэлэлцүүлэг, оролцооны аргуудыг сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үр дүнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн гишүүдийн идэвхи, оролцоо, ойлголт, мэдлэг нэмэгдэж, гэр бүл, хүүхдийн эрхийн зөрчилд яаралтай хариу үйлчилгээ үзүүлэх чадварыг эзэмшсэн. Уг сургалтанд нийт 7,1 сая төгрөг зарцуулсан.	
2.5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйл /улсын орлого болгосон, төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах/-ийг хэрэгжүүлж, тайлагнах	2017 онд аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогод 324.4 сая төгрөг төвлөрсөн ба үүнээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр торгох ял ногдуулж төсөвт төвлөрүүлсэн нийт 203.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн. 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан 66.0 сая төгрөг батлагдаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж байна.	100%
2.6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах”, 12.3 дахь хэсэгт “Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил тутам тогтооно” гэж заасны дагуу тухайн жилд иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоосон эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тодорхой тусгах, тайлагнах	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2018 онд олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог 3 байхаар тогтоож аймгийн төвд 3 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулж цалин урамшуулалд 7.2 сая төгрөг олгосон. Иргэд олон нийт, аж ахуй нэгжийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор 2018.02.26-ны өдрөөс 30 байгууллагын 60 ажилтан, алба хаагчийг аймгийн төвд 18 цагаас 21 цагийн хооронд эргүүлийн цагдаа нарын хамт нийтийн эргүүлд хуваарийн дагуу гарган, 240 хүн/цаг ажиллуулсан. Аж ахуй нэгжүүдийн аюулгүй байдлыг сайжруулах, жижүүрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018.03.22-ны өдөр “Харуул манаа” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 51 байгууллага аж ахуй нэгжийн харуул манааг шалгаж “Энгийн харуул манааны журам” зөрчсөн 5 харуул манаачид зохих арга хэмжээ авч ажиллалаа. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 21 гишүүн 2018.05.01-2018.05.11-ний хооронд нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажиллуулсан. Зөвлөлийн гишүүдтэй хамт цагдаагийн газрын тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудыг хуваарилан хамт ажиллуулсан ба аймгийн хэмжээний эрүү, хэв журмын нөхцөл байдал, цагдаагийн алба хаагчид эргүүл, хяналт шалгалтад ажиллахад тулгардаг хүндрэл бэрхшээлтэй асуудал, орон нутгийн зүгээс шийдвэрлэх шаардлагатай техник хэрэгслийн талаар танилцуулсан. Эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн төрийн албан хаагч нар болон зөвлөлийн гишүүдээс гарсан санал, хүсэлтийг нэгтгэж, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.	70%
2.7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 2	Аймгийн хэмжээнд 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан 66.0 сая төгрөг батлагдаж, уг зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон	100%

	<p>дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг жил бүр тусган санхүүжүүлэх</p>	<p>“Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу зарцуулж байна. Уг зардлаас 2018 оны 5 сарын байдлаар сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 15 сумын ГХУСАЗСЗ-үүдэд ажлын байдлаар ажлын үр дүнг тооцон сумдад 6.0 сая төгрөгний санхүүжилтийг олгож, Олон нийтийн цагдаагийн урамшуулалд 7.2 сая, цашнал урамшуулалд 3.6 сая, ШША, аймгийн Плозурор, ЦГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг 6.3 сая, сургалт, сурталчилгаа, зөвлөгөөнд 5:3 сая төгрөгийг тус тус хууль тогтоомжийн дагуу зарцуулаад байна.</p>	
2.8	<p>Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж, түүний хор уршгийг иргэд, олон нийтэд ойлгуулан таниулах зорилгоор мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах ажлыг эрчимжүүлэх зөрчил дутагдлыг арилгуулахаар 5 аж ахуй нэгжид</p>	<p>2018-2020 онд хэрэгжүүлэх “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт батлууллаа. Уг хөтөлбөрийн гол зорилго нь аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, хорт зуршлаас сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд төрийн болон ТББ, иргэд, аж ахуй нэгжийгидэвхтэй татан оролцуулж, дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтаар хангаж архидалтаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх сөрөг үр дагаварыг бууруулах юм. “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг “Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төв” ТББ, “Монголын Эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг” ТББ, АА бүлэг зэрэг архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-тай хамтран хэрэгжүүлэхээр төсөл, боловсруулаад байна. Архины хамааралтай зорилтот бүлгийн хүмүүсийн амьдралд хандах хандлагыг эерэгээр өөрчилж, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хөтөлбөрт хамруулж, “Говийн хийморь” АА бүлгийн туршлагыг сурталчлах зорилгоор тус бүлгийн 5 жилийн ойн арга хэмжээг 2018.04.28-ны өдөр зохион байгуулахад зохих дэмжлэг үзүүлсэн. Архидан согтуулахтай тэмцэх чиглэлээр “Хуулийн хэрэгжилт”, “Хуулиа мөрдье-21” нэгдсэн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. “Хуулийн хэрэгжилт” арга хэмжээний хүрээнд 3 дугаар сард зарим сумдад сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил хийгдсэн. Тухайлбал: Өлзийт сумын Эрэгтэйчүүдийн зөвлөлөөс “Монгол цэргийн баяр-2018” арга хэмжээг тохиолдуулан архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, архинаас сайн дураараа татгалзаж, гэр бүл, иргэд олон нийтийн итгэлийг хүлээсэн 3 иргэнд талархал хадгалуулах зэрэг ажлыг зохион байгуулсан. “Хуулиа мөрдье-21” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудтай хамтран согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 95 газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 5 аж ахуй нэгжид 17 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтэнд хяналт тавьж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч 7 ААН-ийн эрхийг хүчингүй болгож, үйлчилгээ эрхлэгч 1 ААН-д шинээр эрхийг олгож 112 цэг болгож 5-аар буурууллаа. Дээрх арга хэмжээ, хяналт шалгалтын дүнд өнгөрсөн 5 сарын байдлаар согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 17 гарч өнгөрсөн оны мөн үеэс 6-аар буюу 26.1%-иар буурсан байна.</p>	100%




2.9	Хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүх шатны сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлж, тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах	Хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн байгууллагууд болон холбогдох ТББ-ын дэмжлэг туслалцаатайгаар сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж байна. Эхний хагас жилийн байдлаар Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Хуулиа мөрдөө” нэгдсэн арга хэмжээг аймгийн МХГ, ГБХЗХГ-тай хамтран зохион байгуулж архи түүний хор уршиг холбогдох хууль тогтоомжийн талаар аймгийн төвийн 5 сургууль, МСҮТ-ийн 490 сурагчид сургалт явуулж, хөгжөөнт цэнгээнт танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг зохион байгууллаа. Аймгийн төв номын сантай хамтран арга хэмжээний хүрээнд тараах материал 80 хийж иргэдэд тарааж мэдээлэл өгсөн.Сурагчдыг зам тээврийн болзошгүй осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор School-Police эцэг эхийн эргүүлээр аймгийн төвийн 4 сургуулийн уулзвар гарцан дээр 450 хүн ажиллаж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, сурагчдыг зам тээврийн осол хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлсэн.“Лантуун дохио” ТББ, Сайнцагаан сумын ГХУАЗСЗ, “Дэлхийн зөн” ОНХХ-тэй хамтран Хүчирхийлэл, цахим гэмт хэрэг ба түүний хор уршиг, хүний наймаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “НЭГ АМЬ НЭГ МЭДЭЭЛЭЛ” лекцийг зохион байгуулж, МСҮТ, ЕБС-иудын 9-12 дугаар ангийн 1450 сурагч, 34 хүртэлх насны 195 залуучуудыг хамрууллаа. Цагдаагийн газар, БСУГ-тай хамтран баруун бүсийн 6 сумын ЕБС-ийн 6-12 дугаар ангийн 1032 сурагчид Зам тээврийн болон ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг 964 сурагчдад зохион байгуулсан. “Гэмт хэрэг, зөрчилгүй сургууль” аяныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулиудад Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн 7 хоног зарлаж, цахим гэмт хэргийн ойлголт, архи, тамхины хор уршиг, мансууруулах бодисын талаар сургалт зохион байгуулж сургуулийн нийгмийн ажилтнууд эрсдэлтэй хүүхдийн судалгааг гаргаж хяналт тавин ажиллаж байна. Тэмдэглэлт баяр болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээний дараа сургуулиудын захиргаатай хамтран судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гэрийн хаягаар явж, хяналт тавин ажилладаг.	70%
2.10	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилж, зорилтот бүлгүүд болон хүчирхийлэл үйлдэгчдэд сургалт, сурталчилгаа явуулах	2018 оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн байгууллага, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар зэрэг байгууллагуудтай хамтран 7 сумын 39 байгууллагын 624 хүнд хүнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулсан. Энэ оны 01–05 дугаар сард Цагдаагийн газрын баривчлах байранд хүмүүжиж байгаа зорилтот бүлгийн 14 иргэнд энэ чиглэлээр мэргэшсэн “Оюуны гэгээ” ТББ-аар нийт 3 удаа зан үйлийн албадан сургалтыг зохион байгуулсан. Зан үйлийн албадан сургалт явуулж, хамтран ажиллаж байгаа тухайн ТББ-ын 1 сургагч багшийн сургалтын төлбөр 200.0 төгрөгийг шийдвэрлэж, Улаанбаатар хотод 5 дугаар сард мэргэшүүлэх сургалтанд хамруулсан. 2018 оны 5 пугаар сарын байдлаар Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 4 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс өсөөгүй байна.	70%
2.11	Хүн худалдаалах, эмэгтэйчүүдийг хүүхэд, бэлгийн	Орон нутгийн 2 телевиз, олон дагагчтай 8 цахим хаягаар хүн худалдаалах, мансууруулах бодис, хүчирхийлэл, садар самуун сурталчилсан бичлэг бусад мэдээлэл тавигдахаас	100%

	<p>мөлжлөгийн зорилгоор ашиглах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулж, энэ төрлийн зар сурталчилгаанд хяналт тавих</p>	<p>урьдчилан сэргийлэх зорилгоор телевиз, цахим хаяг хөтөлдөг иргэдийн дунд холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж, баталгаа авч ажиллаж байна. Дундговь аймгийн Фэйсбүүкийн группүүдэд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх 2 төрлийн зурагт сэрэмжлүүлэг, 1 видео бичлэгийг байршуулан иргэдэд түгээж сурталчиллаа. Аймгийн ЦГ, Эрүүл мэндийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж болзошгүй 12 хүний судалгааг гарган 2018 оны 3 дугаар сард дээрх хүмүүст энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, орон нутгийн телевиз, цахим хаягуудад цагдаагийн газраас хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 11 байгууллагын судалгааг гарган аймгийн БОАЖГ-тай хамтран 2 төрлийн сэрэмжлүүлгийг бэлтгэн жуулчны компани, аялал зугаалгаар явж байгаа иргэдэд тарааж сурталчилсан. Хяналт, хамтын ажиллагааны үр дүнд дээрх төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.</p>	
2.12	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажилд бүх талаар дэмжлэг үзүүлэх</p>	<p>Аймгийн хэмжээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл худалдан борлуулах зөвшөөрөлтэй “Дундговь эм хангамж” ХХК нь аймгийн нэгдсэн эмнэлгийн эмийн сан болон эмчийн зөвшөөрлөөр иргэдэд ханган нийлүүлж байна. Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл худалдан борлуулах зөвшөөрөлтэй “МНЧ”, Улаанбаатар хотын “Монос фарм трейд” ХХК-ийн Дундговь аймаг дахь эм ханган нийлүүлэх эмийн сангууд нь жижиглэнгээр эмчийн жоронд заасан хэмжээгээр үйлчилж байна. Дээрх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдийн эмийн сангуудад 2018 оны 02 дугаар сард Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Тагнуулын хэлтэс хамтран эмийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалтанд шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар зөвлөмж, албан мэдэгдэл хүргүүлж, хяналт тавьж ажиллаж байна. Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс үүсэх үр дагавар, хор уршгийг таниулах зорилгоор аймгийн “Аюулаас сэргийлэх цогцолбор” FM-107.5 –аар яриа хийж, фээсбүүкийн “Дундговь аймаг дахь Цагдаагийн газар” болон Дундговийн группүүдээр хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх талаар зурагт зөвлөмжүүд болон шторк байршуулж ажиллалаа. Мөн хууль бусаар эм, бэлдмэл худалдан борлуулж болзошгүй 6 иргэний судалгааг гарган тэдгээрт хяналт тавин ажиллаж байна.</p>	100%
2.13	<p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулж, зохион байгуулах</p>	<p>ЦЕГаас зохион байгуулж буй "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хүрээнд аймгийн мэргэжлийн байгууллагууд хамтран иргэд, олон нийт, ЕБС-ийн сурагчдыг татан оролцуулж энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг, түүнийг таслан зогсоох талаар арга зүйн болоод хууль эрх зүйн сургалт сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгууллаа. Тухайлбал: -Аймгийн Цагдаагийн газраас аймгийн МХГазар, Дэлгэрцогтсумын ЗДТГ-тай хамтран 2018.05.24-ны хууль бусаар байгалийн өнгөт чулуу түүдэг иргэдтэй уулзаж, холбогдох хууль, журмын талаар мэдээлэл өгч, уулзалтын дараа арга хэмжээнд оролцсон иргэдэд улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа "Байгалиа хамгаалъя" арга хэмжээнд</p>	70%

		<p>нэгдэж, байгалийн өнгөт чулуу түүхэд ашигладаг багажаа МХГ-т сайн дураараа хураалгаж, дахин зөрчил гаргахгүй байхаа илэрхийллээ.</p> <p>2018 оны эхний хагас жилд Мэргэжлийн хяналтын газартай хамтран аймгийн 15 сумын байгаль орчны байцаагч нарт “Дундговь аймгийн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн ойлголт, нөхцөл байдал” сэдвээр 1 удаагийн сургалт, мэдээлэл зохион байгуулсан. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн чиглэлээр Говь-угтаал, Баянжаргалан, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж ажилласан бөгөөд уг аж ахуй нэгжүүдэд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй, үйл ажиллагаа эхлээгүй, ямар нэгэн гэмт хэрэг, зөрчлийн шинж илрээгүй. Цагаандэлгэр, Дэлгэрцогт сумын хэсгийн мөрдөгч, байгаль орчны байцаагчийн хамт байгалийн өнгөт чулуу хууль бусаар илрүүлсэн 6 иргэнийг илрүүлэн арга хэмжээ тооцсон болно.</p>	
2.14	<p>Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж, эрчимжүүлэх</p> <p>/Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4, 5 дугаар зүйл/</p>	<p>Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, алдсан болон олдсон малыг эрэн сурвалжлах чиглэлээр аймгийн ОБГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан АС цогцолборын FM-107,5-аар мал бүхий иргэдэд цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ, болзошгүй хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээг тогтмол явуулж хэвшсэн. АС цогцолбор нь Дундговь аймгийн төв, Эрдэнэдалай сумын төв, Говь-Угтаал сумын төвд тус бүр нэг дахин дамжуулах стацны тусламжтайгаа 7000 мал бүхий өрхөд мэдээ, мэдээлэл дамжуулж байна. УБ-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай засмал замаар мал, мах тээвэрлэж яваа автомашин тээврийн хэрэгслүүдийг шалган, хяналт тавьж, үзлэг шалгалтыг хийж гарал үүслийн гэрчилгээг тогтмол шалган ажиллаж байна. Аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн нартай хамтарч мал, махны чиглэлээр гарал үүслийн гэрчилгээ олгож байгаа сумдын мал эмнэлгийн байцаагч нарт мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг зохион явуулж, хамтран ажиллах, хулгай мал, маханд гарал үүслийн гэрчилгээ олгохгүй байх чиглэлээр сэрэмжлүүлэг өгч хяналт тавин ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн телевиз, сонин, радиогоор урьдчилан сэргийлэх яриа таниулгыг тогтмол зохион байгуулж байна. Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар 5 сумын 16 бүлэг нөхөрлөл байгуулан мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэд хамрагдсан. Хариуцсан сумын хэсгийн төлөөлөгч цагдаа нар нь бүлгийн ахлагч нарыг мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЦГ-аас мэргэжлийн удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагаа сэдэвт бүсийн зөвлөгөөн Төв аймгийн Зуунмод суманд болсон өвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга С.Сүхбаатар, аймгийн Цагдаагийн газрын дарга Ц.Сугаржав болон холбогдох албан хаагчийн хамт оролцож, зөвлөгөөний шийдвэр анхаарах асуудлыг эрчимжүүлж сум, мэргэжлийн байгууллага, алба хаагчдыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Дээрх ажил, арга хэмжээний дүнд 2018 оны 05 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 131 гэмт хэрэг бүртгэгдсэний 60 буюу 45.8 хувийг өмчлөх эрхийн эсрэг</p>	100%

		гэмт хэрэг эзэлж байгаагаас 8 буюу 13.3 хувийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад мал хулгайлах гэмт хэрэг 42.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
2.15	Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи, цахим зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол/	Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн гэмт хэргийн суурь гэмт хэрэг буюу авилга авах, өгөх, хөрөнгө завших, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг илрүүлэх, шалгах, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж болзошгүй сэжиг бүхий этгээд, гэмт үйлдлийн талаар мэдээлэл цуглуулж зохих хяналт тавьж байна. Аймгийн нутаг дэвсгэрт террорист үйлдлийн эсрэг ажиллагаанд үүрэг гүйцэтгэх тусгай зориулалтын бүлэг Цагдаагийн газарт байгуулан шаардлагатай бэлэн байдлыг хангасан. Тус аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа гадаадын иргэдийг тухай бүрд нь бүртгэн авч, террорист үйлдэл хийх, бүлэглэлд элсүүлэх, нутагшуулах, санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлж, үйл хөдлөлд нь хяналт тавьж байна. Гадаадын иргэдэд 2 удаа шалгалт хийж илэрсэн зөрчлийг холбогдох газарт мэдэгдэж ажилласан. Тус аймагт 2017 онд 2018 оны эхний хагас жилд мөнгө угаах гэмт хэрэг бүртгэгдээгүй. Аймгийн хэмжээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл худалдан борлуулах зөвшөөрөлтэй “Дундговь эм хангамж” ХХК нь аймгийн нэгдсэн эмнэлгийн эмийн сан болон эмчийн зөвшөөрлөөр иргэдэд ханган нийлүүлж байна. Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл худалдан борлуулах зөвшөөрөлтэй “МНЧ”, Улаанбаатар хотын “Монос фарм трейд” ХХК-ийн Дундговь аймаг дахь эм ханган нийлүүлэх эмийн сангууд нь жижиглэнгээр эмчийн жоронд заасан хэмжээгээр үйлчилж байна. Эмийн сангуудад 2018 оны 02 дугаар сард аймгийн ЦГ, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Тагнуулын хэлтэсийн холбогдох албан тушаалтануудтай хамтран эмийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалтанд шалгалт хийж ажиллан илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар зөвлөмж гарган албан мэдэгдлийн хамт хүргүүлж хяналт тавьж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна. “Аюулаас сэргийлэх цогцолбор” FM-107.5, орон нутгийн “Цоглог”, “Ард” телевизүүдээр хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс гарах үр дагавар, хор уршиг болон “Цахим гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга, сурталчилгаа хийж, фээсбүүкийн “Дундговь аймаг дахь Цагдаагийн газар” болон Дундговийн группүүдээр хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх талаар зурагт зөвлөмжүүд болон шторк, хүн худаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн зурагт сэрэмжлүүлэг, 1 видео бичлэг байршуулан сурчлалчилсан. Аймгийн ЦГ-аас хууль бусаар эм, бэлдмэл худалдан борлуулж болзошгүй 6 иргэний судалгааг гарган тэдгээрт хяналт тавьж байна. “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЦГ, ЭМГ, Хүүхэд, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж болзошгүй 12 хүний судалгааг гарган 2018 оны 3 дугаар сард дээрх хүмүүст энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 11 байгууллагын судалгааг гарган аймгийн БОАЖГ-тай хамтран 2 төрлийн сэрэмжлүүлгийг	100%

		бэлтгэн жуулчны компани, аялал зугаалгаар явж байгаа иргэдэд тарааж сэрэмжлүүлээ. Цахим орчноор дамжин үйлдэгдэж байгаа гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Цахим орчин дахь гэмт хэрэг” нэртэй хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 05 дугаар сард зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Монгол банкны салбар, арилжааны банкуудтай хамтран интернэт банк, онлайн төлбөрийн системтэй холбоотой болон цахим төлбөр тооцооны хэрэгслийн мэдээллийг ашиглан хуурамч гүйлгээ хийх, интернэт залилан мэхлэх гэмт хэргийн талаар хэрэглэгчдийг хэрхэн хамгаалах талаар хэлэлцүүлэгийг 2018 оны 05 дугаар сарын 16-нд зохион байгуулсан.	
2.16	Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн тус аймаг дахь салбар говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төвийн хамгаалах байрны засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх	Аймгийн Засаг даргын 2018 оны А/47 дугаар захирамжаар Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төвийн хамгаалах байрны 8 цонхонд дохиолол суулгаж, гал тогооны өрөөнд утаа мэдрэгч байршуулах зардал болон урсгал зардалд 1.831.960 төгрөг нийт 2.812.836 төгрөгийг шийдвэрлэснээр хэвийн ажиллах нөхцөл бүрдсэн. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран 2018 онд хоол хүнс, ажилтны цалин болон мэргэшүүлэх 3 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 3.318.500 төгрөгийг тус тус зарцуулаад байна.2018 оны эхний 5 сарын байдлаар 3 насанд хүрэгч, 3 хүүхэд, нийт 6 үйлчлүүлэгчийг түр хамгаалах байранд 33 хоног байрлуулан үйлчилгээ үзүүллээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- 1 иргэнийг аймгийн иргэний бүртгэлд бүртгүүлэн, шилжилт хөдөлгөөн хийлгэж, иргэний үнэмлэхтэй болгосон.</li> <li>- 1 хүүхдийг төрсний гэрчилгээтэй болгосон.</li> <li>- 2 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулан, эмчийн зөвлөгөөний дагуу эмчилгээ хийлгэсэн.</li> <li>- 1 үйлчлүүлэгчийг ХХҮГ-ын “Цалинтай ээж” хөтөлбөрт хамруулсан.</li> <li>- 6 үйлчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөөг шат дараалан өгч, тайвшруулах үйлчилгээ үзүүлсэн.</li> <li>- 1 иргэнийг хүүхдийн тэтгэмж тогтоолгох нэхэмжлэх бичихэд холбон зуучлах үйлчилгээнд хамруулсан.</li> </ul>	100%
<b>Гурав. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр</b>			
3.1	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, ялангуяа гудамж, талбай, улсын чанартай автозамын телекамерын	2015 онд аймгийн төв Мандалговь хотод гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай, олон нийтийн газар, эмзэг цэгүүдийг судлан 62 ширхэг телекамер суурилуулж нутаг дэвсгэрийн 65 хувийг хяналтад авах боломжтой болсон тавигдсан 62 ширхэг телекамерын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр цагдаагийн газрын Холбоо, мэдээллийн инженер тогтмол засвар, үйлчилгээ хийж байна. Эдгээр хяналтын камерын ашиглалтыг сайжруулах зохилгоор 2018 оны ОНХС-ийн 53,9 сая төгрөгийн хөрөнгөөр “Буянт гүүрнээс МТ шатахуун түгээх станц хүртэл гадна гэрэлтүүлэг”-ийн ажлыг “Анар зоне” ХХК-тай гэрээ байгуулан 35ш гэрэлтүүлэг хийлгэсэн. “Авто замын гэрлэн дохио”	70%

	<p>хяналтын нэгдсэн системийг бий болгох, өргөтгөх, урсгал зардлыг шийдвэрлэж, ашиглалтад хяналт тавих</p>	<p>ХХК-аар Аюулгүйн тойрог, Жаст ойл ШТС-ын авто замын уулзваруудад гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах ажлын зураг төсвийг 3,5 сая төгрөгөөр боловсруулан хүлээн авч, 2018 оны замын сангийн 185,999,900 төгрөгийн хөрөнгөөр Хүүхдийн паркаас МТ ШТСтанц хүртэл 1,48 км явган хүний замын ажлын үлдэгдэл 71,298,594 төгрөг, Аюулгүйн тойргийн авто замын уулзварын гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах ажилд 66,738,574 төгрөг, Жаст ойл шатахуун түгээх станцын авто замын уулзварын гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах ажилд 47,962,732 төгрөгний ажил хийгдэхээр болоод байна.</p> <p>Аймгийн төвийн гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр алсаас хяналт тавих боломж бүхий хүчин чадалтай 4 ширхэг нисдэг дрон камерыг Дэлхийнзөн Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс дэмжиж Сайнцагаан сумын ЗДТГ-аас 2.000.000 төгрөгтбагтаан 1 ширхэг нисдэг дрон камерыг тус сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдаанаар шийдвэрлэж уг нисдэг дрон камерыг худалдан авч байгууллагын үйлажиллагаанд ашиглаж байна.</p> <p>“Сэрэмжилье-нэгдье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж аж ахуй нэгжүүдэд телекамерыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЦГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс хамтран аймгийн хэмжээнд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй 8 аж ахуйн нэгжийн судалгааг шинэчилэн гаргаж, хяналт шалгалт хийж “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний стандартыг / MNS 5274-2017” хэрэгжүүлж ажиллах талаар 7 заалттай 03 тоот албан мэдэгдэл хүргүүлж биелэлтийг тооцсон.</p>	
3.2	<p>Аймаг дахь цагдаагийн газарт шаардлагатай байгаа тээврийн болон холбооны хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>2018 оны эхний хагас жилийн байдлаар ЦГ-тТИ-Сам загварын 41 сая төгрөгний өртөгтэй иж бүрэн зөөврийн хурд хэмжигч 1 ширхэг багажийг шийдвэрлүүлсэн. ЦЕГ-аас 2018 онд хөдөлгөөнт эргүүлд ашиглагдаж байсан 1 автомашиныг 3 сард хүлээн авч, дахин 1 шинэ автомашин авахаар болсон. Аймгийн төв Сайнцагаан сумын ЗДТГ-аас Цагдаагийн хэсэгтээ 1 ширхэг нисдэг дрон камер шийдэж, Замын хяналтын постод 3.5 сая төгрөгний засвар үйлчилгээ хийж, 1 автомашиныг ирэх улиралд олгохоор тус тус шийдвэрлэсэн.</p>	70%
3.3	<p>Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын ажилтан, алба хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулах</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан туршлага, мэдээлэл солилцох зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон талт хамтын ажиллагаа” аймгийн зөвлөгөөнийг 2018 оны 04 сарын 11 ны өдөр зохион байгуулж, зөвлөгөөнд ХЗДХЯ-ны ГХУСАЗЗАА, аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчид, сумдын Засагдарга, ИТХ-ын дарга, хэсгийн мөрдөгч нар оролцож тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж саналаа нэгтгэж, зөвлөгөөнөөс зөвлөмж гарган хэрэгжүүлж, хамтран ажиллаж байна.</p>	100%


		Эрүүгийн хэрэг шалгах явцад гарсан маргаантай болон шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа асуудал, шинээр мөрдөж байгаа хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд анхаарч, аймгийн ЦГ, Прокурорынбайгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг сар бүр хийж, зааварчилга, чиглэл авч хэвшсэн.	
3.4	Шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, сурталчлах, цагдаагийн байгууллагад учирч буй хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр санаачилга гарган ажиллах	2018 онд Цагдаагийн газраас алба хаагч нарт зохион байгуулах албаны сургалтын төлөвлөгөө гарган баталсан хуваарийн дагуу 2018 оны 05 сарын байдлаар 2411 алба хаагчид 58 удаагийн сургалт зохион байгууллаа. Шинээр батлагдсан хууль тогтоомжийн 13 удаагийн 15 цагийн сургалтад 616 алба хаагч, бусад хууль тогтоомжийн 9 удаагийн 11 цагийн сургалтад 328 алба хаагч, алба хаагчдыг хөгжүүлэх 3 удаагийн 3 цагийн сургалтад 137 алба хаагч, бие бялдарын 13 удаагийн 39 цагийн сургалтад 546 алба хаагчийн тус тус хамруулсан. Цагдаагийн байгууллагаас санаачилсан болон төлөвлөгөөт үйл ажиллагаанд аймаг, сумдын удирдлагууд хөрөнгө санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг туслалцааг үзүүлж байна. Тухайлбал: 2018 онд Баянжаргалан, Дэлгэрцогт сумд Бэлэн бус хэлбэрээр торгуулийн багаж шийдвэрлэсэн, -аймгийн ЦГ-т TI-Cam загварын 41 сая төгрөгний өртөгтэй иж бүрэн зөөврийн хурд хэмжигч 1 ширхэг багажийг шийдвэрлүүлсэн. - Эрдэнэдалай сумын ЗДТГ-аас Цагдаагийн хэсэгтээ мотоцикль авч өгсөн, - Сайнцагаан сумын ЗДТГ-аас Цагдаагийн хэсэгтээ 1 ширхэг нисдэг дрон камер шийдэж, Замын хяналтын постод 3.5 сая төгрөгний засвар үйлчилгээ хийсэн.	70%
3.5	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх	Улсын хэмжээнд болон аймгийн Цагдаагийн газраас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, иргэдийн өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг, зөрчлийг цаг алдалгүй шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг иргэдийн оролцоо, идэвх санаачлагад тулгуурлан зохион байгуулж, нутаг дэвсгэр, гудамж талбай, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Хуулиа мардые-21”, “Сэрэмжилье-нэгдье”, “Хуулийн хэрэгжилт”, “Сар шинэ”, “Бяцхан зорчигч”, “Байгалиа хамгаалъя” нэгдсэн болон бусад хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргаас тухай бүр шаардлагатай зохион байгуулалтын болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллаж байна.	70%
3.6	Эрүүлжүүлэх, саатуулах байрны хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх	Аймгийн Засаг даргын захирамжаар цагдаагийн газрын шинээр баригдах контор, спорт заал, эрүүлжүүлэх саатуулах байрны газрын асуудлыг шийдвэрлүүлж, хуучин цагдаагийн газрын зүүн урд тал газар эзэмшүүлэх захирамж гарсан. Цагдаагийн газрын контор, эрүүлжүүлэх баривчлах байр болон спорт заалны барилгыг бариулахаар 2,5 тэрбум төгрөгийн өртөгтэй зураг, төсвийг гаргуулсан. ИТХ-ын дэргэдэх Иргэний Зөвлөлөөс тус Цагдаагийн газрын барилга байгууламж/ Эрүүлжүүлэх, саатуулах байр/-д цаашид үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй, албаны автомашинуудын парк шинэчлэл хийх шаардлагатай байгаа талаар ЦЕГ-ын дарга, Хууль зүй дотоод хэргийн сайдад хүсэлт	70%

3.7	Томилогдсон болон алслагдсан суманд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, түүний гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах болон бусад дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах. /Цагдаагийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл/	хүргүүлсэн. Аймгийн бүх сумдын буюу 15 суманд хэсгийн төлөөлөгч, цагдаа нар бүгд Цагдаагийн кобанд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Цагдаагийн албаны тухай хуулийн 31.1-ийг үндэслэн аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд “Суманд ажиллаж буй цагдаагийн кабоны байрны хэсгийн цахилгаан зөвхөн ажлын байрны дулаан, түлш, шатахуун, бичиг хэрэг, унаа, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх, ажлын байраар хангах талаар” тусган зохицуулж, хөдөө сумдад 28 алба хаагч албаны байранд гэр бүлтэйгээ амьдарч, гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангаж байна. Тухайлбал: -2018 оны эхний хагас жилд Гэмт хэрэг, зөрчил хамгийн их гардаг, аймгийн төв орох зам дагуу байршилтай Дэлгэрцогт, Луус сумд Орон нутгийн хөгжлийн сангаасаа цагдаагийн хэсгийн үйл ажиллагааг дэмжин 4.0 сая төгрөгөөр бэлэн бусын торгуулийн төхөөрөмжөөр хангасан, -Хулд ОНХС-аас сумын төвийн болон төв замын мал явдаг газраар замын тэмдэг тэмдэглэгээ хийх, үхэр малыг гэрэлтдэг хүзүүвчтэй болгоход 2,0 сая төгрөг зарцуулсан. -Хамгийн олон хүн амтай Эрдэнэдалай сумын цагдаагийн хэсгээ дэмжин мотоциклоор хангасан.	70%
3.8	“Иргэний зөвлөл”-ийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хараат бус байдлыг хангахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх. /Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дүгээр зүйл/	Аймгийн Цагдаагийн газраас 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр “Иргэний Зөвлөл”-д 2017 оны үйл ажиллагаа тайлагнаж, гишүүдийн саналыг хүлээн авч 2018 онд хэрэгжүүлэх, анхаарах чиглэлээ танилцуулж, Зөвлөлд шаардлагатай мэдээлэл гаргаж өгч, хараат бус байдлыг хангахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Цагдаагийн байгууллагаас үйл ажиллагааны Иргэний зөвлөл, иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор тайлангаа видео хэлбэрээр бэлтгэн аймгийн төвийн сумын төвийн 5 багийн 190 гаруй иргэдэд сурталчилж, тайлангаа танилцуулж, санал асуулга авч нэгтгэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.	70%
3.9	Цагдаагийн газрын барилга болон сумдын цагдаагийн <b>кабон</b> , постын байранд урсгал засвар, бусад шаардагдах зардлыг шийдвэрлэх	Суманд ажиллаж буй цагдаагийн кобаны байрны хэсгийн цахилгаан зөвхөн ажлын байрны дулааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх асуудлыг сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд жил бүр тусган зохицуулж байна. Тус аймгийн Адаацаг, Өндөршил сумдын хэсгийн кобаны халаалтыг сум, орон нутгийн зардлаар төвлөрсөн халаалтад шилжүүлэх ажлыг эхлүүлсэн.	70%
3.10	Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цаашид авч хэрэгжүүлэх арга	Аймгийн Цагдаагийн газраас аймгийн хэмжээний гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын талаарх мэдээллийг гарган, нөхцөл байдалд дүгнэлт, судалгаа хийж сар бүр, шаардлагатай үед тухай бүр аймаг, сумдын Засаг дарга нар, ГХУСА33-д нийт 39 удаа танилцуулга мэдээлэл өгч, зохих арга хэмжээ авч байна. Цагдаагийн газраас гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх сонсгол, мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр аймгийн ЗДТГ-ын 2018 оны төлөвлөгөөнд туссан бөгөөд 6 дугаар сарын сүүлчээр болох	Х/Б



	хэмжээг тодорхойлох, үр дүнг тооцох /ГХУС тухай хуулийн 16 дугаар зүйл/	Зөвлөлийн хурлаар орох болоод байна.  <b>(Хугацаа болоогүй)</b>	
3.11	Хүний эрх зөрчигдөж байгаа зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт, зөвлөгөөн, хяналт шалгалт зохион байгуулж, үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлах /Хүний эрхийн үндэсний комиссын 2016 оны 15 дугаар илтгэл/	Аймгийн хууль хяналтын байгууллагуудтай болон “Хуульч эмэгтэйчүүдийн холбооны салбар”, “Оюуны гэгээ” зэрэг ТББ-уудтай хамтран хүний эрх зөрчигдөж байгаа зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх ажлуудыг хамтран хэрэгжүүлж байна. Хэрэглэгчийн эрхийг хагаалах тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Хэрэглэгчийн өдөр” сарын аяны удирдамж боловсруулан сумдад хүргүүлж 2018.05.15-06.15-ны хооронд зохион байгуулж, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэсэн сурталчиггаа, нөлөөллийн ажлыг сумдад зохион байгууллаа. Сайнцагаан сумын ЗДТГ-тай хамтран “Хяналт шалгалт” арга хэмжээг 2018.04.27-ны өдөр зохион байгуулж, аймгийн төвд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 53 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж 10 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 100.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авсан байна. Аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын ахлах мэргэжилтэнтэй хамтран “Хүний эрхийн үндсэн ойлголт” сэдвээр ЦГ-ын алба хаагч нарт сургалт зохион байгуулж хүний эрхийн зөрчилтэй тэмцэх, хамтран ажиллах арга зүйн талаар мэдлэг мэдээлэл хүргэсэн. “Цагдаагийн ажилтан ба хүний эрх” сэдэвт сургалтанд 2018 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Хэрэг бүртгэх тасгийн дарга хамрагдаж Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн б/354 тоот тушаалаар хүний эрхийн сургалтыг зохион байгуулах сургагч багшаар томилогдон, цагдаагийн алба хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч байна. Хүний эрхийн үндэсний комиссын 2016 оны 15 дугаар илтгэлийг ХЭҮК-ийн төлөөлөгчтэй хамтран иргэд олон нийтэд сурталчлан хэрэгжүүлж байна.	70%
3.12	Олон нийтийн цагдаагийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцсаар хангаж, тусгай хэрэгсэл, цалин, урамшууллын асуудлыг шийдвэрлэж санхүүжүүлэх, ажлын үр дүнг тооцох /Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйл/	Аймгийн ИТХ-аас аймгийн төвд 3 олон нийтийн цагдаа ажиллуулахаар тогтоож аймгийн төв Сайнцагаан суманд 3 олон нийтийн цагдаа ажиллаж байгаа. Олон нийтийн цагдаагийн ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, нэг бүрийн тусгай хэрэгслээр 2016 онд бүрэн хангасан өгсөн. Аймгийн Цагдаагийн газраас Олон нийтийн цагдаа нарыг өдөр тутам мэргэжлийн удирдлагаар хангаж, албаны сургалт, биеийн тамирын хичээлд тогтмол хамруулж байна. Үндэсний төв архивын газраас зохион байгуулж байгаа “Архив, албан бичгийн хөтлөлт” сэдэвт 1 сарын хугацаатай сургалтанд, Жолооны курсын “С” ангиллын сургалтанд тус бүр 1 олон нийтийн цагдааг, 1 олон нийтийн цагдааг цагдаагийн анхан шатны курсын шалгалтанд хамруулаад байна. Олон нийтийн цагдаагийн ажилтан цагдаагийн алба хаагчдын хамт хэв журмын эргүүл, шалгалтад ажиллахдаа илрүүлсэн 86 зөрчилд цагдаагийн алба хаагчаар торгуулийн арга хэмжээ авсан байна.	70%
3.13	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан	Аймгийн хууль хяналтын байгууллагууд болон Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн	100%

<p>сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Номын сан, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, МСҮТ, ЕБС-иуд болон “Хуульч эмэгтэйчүүдийн холбоо”, “Оюуны гэгээ” ТББ, “Лантуун дохио” ТББ, “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ зэрэг байгууллагуудтай хамтрангэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Хуулиа мардые-21”, “Сэрэмжилье-нэгдые”, “Хуулийн хэрэгжилт”, “Сар шинэ” арга хэмжээнүүдийн хүрээнд ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд тавигдсан зорилтод нэвтрүүлэг, видео, шторкыг цагдаагийн газрын болон сумдын ГХУСАЗСЗ-ийн пэйж хуудсанд байрлуулж иргэд олон нийтэд мэдээлсэн.</li> <li>- Аймгийн ГХУСАЗСЗ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргахад багийн Засаг дарга нар сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангах, чадавхжуулах зорилго бүхий “Гэр бүл, хүүхдийн хөгжилд багийн Засаг дарга, хорооны хэсгийн ахлагчийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг сумдын 66 багийн Засаг дарга, сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн нийт 81 хүн оролцож байна.</li> <li>- “Хуулиа мөрдөө” нэгдсэн арга хэмжээний хүрээнд ЦГ, МХГ, аймгийн төв номын сантай тус тус хамтран архи түүний хор уршиг холбогдох хууль тогтоомжийн талаар аймгийн төвийн 5 сургууль, МСҮТ-ийн 490 сурагчид сургалт явуулж, хөгжөөнт цэнгээнт танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг зохион байгуулж, 80 иргэнд мэдээлэл, брошур материал тараасан.</li> <li>- Сумдын хамтарсан багийн 154 гишүүнийг хамруулан Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, осол, хүчирхийлэлд өртсөн иргэд, хүүхдийн мэдээллийг хүлээн авч, шалган, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийж, мэргэжлийн цогц үйлчилгээг багаар үзүүлэх чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулсан</li> <li>- “ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД ЭХ ДЭЛХИЙГЭЭРЭЭ НЭГДЬЕ” аяны хүрээнд Дэлгэрхангай, Сайнхан-Овоо, Эрдэнэдалай, Луус, Хулд, Адаацаг, Сайнцагаан сумдын 703 хүүхэд, 995 эцэг эх, асран хамгаалагч нийт 1698 иргэнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх сургалт, нөлөөллийн ажиллагаа явуулсан.</li> <li>- Сургууль бүр дээр өсвөрийн сэргийлэгч бүлгэм ажиллаж сурагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох, үе тэнгийн нөлөөллийн ажлыг зохион байгуулан явуулж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагийн газар, “Дэлхийн зөн” ОНХХ-тэй хамтран Хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудыг бий болгох, хөгжүүлэх зорилгоор 2017-2018 оны хичээлийн жилд “Нэг сургууль – Арван клуб” аяныг Дундговь аймгийн Сайнцагаан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Адаацаг, Гурвансайхан сумын нийт</li> </ul>
--	---

		<p>есөн сургуулийн 90 клуб ажиллуулж, 1931 хүүхдийг чадавхжуулан арга хэмжээг сурталчилж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “НЭГ АМЬ НЭГ МЭДЭЭЛЭЛ” лекцээр МСҮТ, ЕБС-иудын 9-12 дугаар ангийн 1450 сурагч, 34 хүртэлх насны 195 залуучуудад мэдлэг мэдээлэл өгсөн.</li> <li>- Аймгийн баруун бүсийн 6 сумын ЕБС-ийн 6-12 дугаар ангийн 1032 сурагчид Зам тээврийн болон ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг 964 сурагчдад зохион байгуулсан.</li> </ul>		
3.14	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Шалгах багаж”-ны тоог нэмэгдүүлэх, шаардлагатай багаж, төхөөрөмжөөр хангах /автомашины утас, хурд, шилний гэрэл нэвтрүүлэх чадвар шалгах, жолоочийн согтуурал хэмжигч, тандагч багаж г.м/</p>	<p>Аймгийн хэмжээнд бэлэн бус торгуулийн багаж 10 ширхэгийг ашиглаж байгаагаас 5 хөдөө сумдад ашиглаж байна. 1 ширхэг багажийг шийдвэрлэснээс 2018 оны эхний хагас жилийн байдлаар Баянжаргалан, Дэлгэрцогт сумдын Засаг дарга нар орон нутаг хөгжлийн сангйн хөрөнгөөр сумын цагдаагийн хэсэгтээ тус бүр 1 багажийг шийдвэрлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хурд хэтрүүлсэнээс үүдэлтэй зам тээрийн ослыг бууруулах зорилгоор Замын цагдаагийн албанд хурд хэмжигч багаж авах санал тавьж 2018.05.23-нд TI-Cam загварын 41.0 сая төгрөгний өртөгтэй иж бүрэн зөөврийн хурд хэмжигч 1 ширхэг багажийг шийдвэрлүүлсэн.</p>	70%	
3.15	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах зорилгоор 2018 онд Улаанбаатар-Мандалговь /А0101/, Мандалговь-Даланзадгад /А0102/ чиглэлийн дугаартай улсын чанартай хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажилд 782м2 талбайн эвдэрсэн хэсгийг халуун асфальт бетон хольцоор нөхөөсийн ажлыг “ТӨВ АЗЗА” ХХК хийж гүйцэтгэсэн. 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдөр УБ-Мандалговь /А0201/, Мандалговь-Даланзадгад /А0202/ чиглэлийн улсын чанартай авто замын дагуу км-ийн босоо тэмдэг шинээр суурилуулах ажлыг “ДАШ ЗАМ” ХХК гүйцэтгээд байна. УБ-Мандалговь /А0201/ чиглэлийн авто замын 49-89км хооронд зорчих хэсгээс 2 тийш 60м зайд байгаа үхсэн малын сэг зэм цэвэрлэх, зурвас газрын хог цэвэрлэх ажлыг хийсэн. Одоо А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замд асфальт бетон хучлагын ан цав, хагарлын заадас гагнах ажил, хөвөө шуудуу сэргээх ажил хийгдэж байна. 2018 оны замын сангийн хөрөнгөөр аймгийн төвийн аюулгүйн тойргийн авто замын уулзварын гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах 66,738,574 төгрөгийн, Жаст ойл шатахуун түгээх станцын авто замын</p>		70%

		уулзварын гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах 47,962,732 төгрөгийн ажлуудыг хийхээр “Авто замын гэрлэн дохио” ХХК-аар Аюулгүйн тойрог, Жаст ойл ШТС-ын авто замын уулзваруудад гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах ажлын зураг төсвийг 3,5 сая төгрөгөөр боловсруулан хүлээн аваад байна. Хурд хэтрүүлсэнээс үүдэлтэй зам тээрийн ослыг бууруулах зорилгоор Замын цагдаагийн албанд хурд хэмжигч багаж авах санал тавьж 2018.05.23-нд TI-Cam загварын 41.0 сая төгрөгний өртөгтэй иж бүрэн зөөврийн хурд хэмжигч 1 ширхэг багажийг шийдвэрлүүлсэн. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 146-р тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулахаар хүргүүлсэн.	
<b>Дөрөв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр</b>			
4.1	Аймагт шинээр баригдан ашиглалтад орж буй орон сууцнаас ШШГ-т тодорхой тооны байрыг албаны мэдэлд шилжүүлэн гэрээгээр эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинээр томилогдон ирсэн алба хаагчдын гэр бүлийн хүнийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	Тус газрын 12 айлын орон сууцны 7 орон сууцыг 2017 онд одоо амьдарч буй алба хаагчдад үнэгүй хувьчилж өгсөн ба 5 орон сууцыг томилолтоор шилжин ирсэн алба хаагчдад хувиарлан өгч, гэр бүлийг ажлын байр, хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт хамрагдаж буй байдалд дэмжлэг үзүүлэн ажиллуулж байна.	100%
4.2	Иргэний нийгмийн байгууллагууд болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хоригдолд төрөл бүрийн мэргэжил, чадамжтай болоход чиглэсэн орчин бүрдүүлэн, сургалт зохион байгуулж тэднийг нийгэмшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаатай болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	С.Буяннэмэхийн нэрэмжит аймгийн Төв номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулан хоригдол, хоригдогчийн санал хүсэлтэнд тулгуурлан “Зөөврийн номын сан”-гаар 14 хоногт 1 удаа үйлчилж нийт 23 хоригдол хоригдогчид /давхардсан тоогоор/ 2018 онд 40 ширхэг номоор үйлчилсэн.Хамгаалалтын ажилтан, ахлагч ахлагч Х.Сандаг-Очирын санаачилгаар 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр аймгийн С.Буяннэмэхийн нэрэмжит төв номын сангаас тус газрын номын санд шинэ номын дээжис болон номын тавиур, 100 ширхэг уран зохиолын ном хандивлах ажлыг зохион байгуулсан нь хоригдол, хоригдогчийг нийгэмшүүлэх орчинг бүрдүүллээ. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж 2018 онд “Дэлхийн Зөн Олон Улсын байгууллага Монгол”-той хамтран ажиллаж орчин үеийн сургалтын шинэ арга хэрэгслийг нвэтрүүлэх, сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, бусад хэрэгслүүдийг нэмэгдүүлэхэд чиглэсэн 2.500.000 төгрөгний төсөл дэмжигдэж өнөөдрийн байдлаар олон үйлдэлт цахилгаан оёдлын машин 2ш, ноос сэмлэгч 1ш, хөлөгт тоглоом 100 буудалт даам 10ш, шатар 10 ш, шатрын цаг 4ш, шинэ үеийн уран зохиолын 35 ширхэг номоор тус тус хөрөнгө оруулалт хийгдсэн. Уг тоног төхөөрөмжөөр тус газрын Цагдан хорих байрны аж ахуй үйлчилгээнд ял эдэлж буй хоригдол нарт оёдлын болон ноос сэмлэгч машинтай хэрхэн харьцах, ашиглах талаар 2 удаагийн сургалт зохион байгуулаад байна.	70%

4.3	Хорих ангийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, орон нутгийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн арга хэмжээнд ялтнуудыг татан оролцуулах замаар тэдний хөдөлмөр эрхлэх, цалин хөлс авч, бусдад учруулсан гэм хорын хохирлоо төлөх, ар гэртээ тус нэмэр болох, ажил мэргэжлийн дадал, ур чадвар, чадамж эзэмшүүлэн төлөвшүүлэхэд хамтын ажиллагааг эрчимжүүлэх	2018 онд аж ахуй үйлчилгээнд ял эдэлж буй 1 хоригдолд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран холбогдох материалыг бүрдүүлэн цахим үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулсан. 2018 оны эхний хагас жилд хорих ялаас хугацааны өмнө суллагдсан 1, хорих ялын хугацаа дуусч 1, нийт 2 хоригдол суллагдсан ба тэднийг ажлын байраар хангах зуучлах асуудлаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгүүлээд байна.	30%
4.4	Хорих байгууллагаас суллагдсан иргэдийг бичиг баримтжуулах, нийгмийн халамж, үйлчилгээнд хамруулах, ажлын байраар хангахад зуучлан хамтран ажиллах	Хорих ангийн тогтолцоогүй үйлдвэрлэл эрхэлдэггүй ба аж ахуй үйлчилгээндээ 8 хоригдлын зөвшөөрөлтэй, одоогийн байдлаар 3 хоригдол тогоочийн туслах, цэвэрлэгчийн ажлын заалтанд ял эдэлж байна. 2018 онд аж ахуйн үйлчилгээнд ял эдэлж буй 1 хоригдолд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран иргэний үнэмлэхтэй болгох ажлыг зохион байгуулсан.	30%
<b>Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр</b>			
5.1	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор төрийн архивын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулах, орон тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны Б/05 тушаалаар Тамгын газрын архивт орон тооны ажилтныг шинээр томилон ажиллуулж орон тоо бий болголоо. Төсвийн хүрэлцээгүй байдлаас хамаарч аймгийн Архивын тасагт шинээр орон тоо нэмэгдээгүй, хуучин орон тоогоор ажиллуулж байна. Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх, аюулгүй байдлын баталгааг бий болгох, архивын шаардлага хангасан өрөө тасалгааг нэмэгдүүлж тохижуулах, өрөөнүүдийн гэрэлтүүлгийг шинэчлэх зэрэг заалтыг тусгаж оруулснаар архивын уншлагын танхимд их засвар хийж засвар тохижилтонд нийт 2 000 000 гаруй төгрөгийн хөрөнгийг зарцууллаа.	70%
5.2	Архивын байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой дэмжлэг үзүүлж, орон сууцны	МУ-ын архивын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгад байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг Төрийн захиргааны ангилалд оруулах, цалингийн шатлалыг нэмэгдүүлэх саналыг Архивын ерөнхий газарт хүргүүлсэн. Архивын Ерөнхий газрын даргын 2018 оны А/18 тушаалаар Төрийн архивын архивч-операторчдын хоолны зардлыг өдрийн 5000 төгрөг болгон нэмэгдүүлж, сар бүр ажлыг	70%

	хөнгөлөлтөнд хамруулахад дэмжлэг үзүүлэх	дүгнэж ур чадварын нэмэгдлийг 15-25 хувиар олголоо. Архивын салбарт удаа жил ажилласан архивын тасгийн даргыг 420 айлын Орон сууцны хөнгөлөлтөд хамрууллаа.	
5.3	Төрийн архивын нийт баримтын 30-аас доошгүй хувийг цахим хэлбэрт оруулах, цахим мэдээллийн сан үүсгэж, баримтын хамгаалалтын болон ашиглалтын хувь үйлдэж, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх арга хэмжээг авах	Үндэсний хөтөлбөрийн 4 дэх үе шатны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018 онд 19 хөмрөг үүсгэгч байгууллагыг цахим санд оруулахаар төлөвлөснөөс эхний хагас жилд 73% буюу 14 хөмрөг үүсгэгч байгууллагын 195 ХН буюу 13715 хуудас баримтанд тодорхойлон бичилт хийж, 6 хөмрөгийн 164 ХН-ийн 11056 хуудас баримтанд холболт хийж, 6 хөмрөгийн 265 ХН-ийн 16004 хуудас баримтыг скайнердаж, 6 хөмрөг үүсгэгч байгууллагын 225 ХН буюу 13710 хуудас баримтанд засвар хийлээ.	70%
<b>Зургаа. Оюуны өмч, улсын бүртгэлийн чиглэлээр</b>			
6.1	Архивын өрөөний тавиурын тоог нэмэгдүүлж стандартын дагуу тохижилтийг хийж гүйцэтгэх	Тус хэлтсийн архивт эхний хагас жилд нэмэгдсэн хувийн хэргийг зориулалтын 5 сейфэнд байрлуулан өргөтгөсөн. Тус хэлтсийн архивын өрөөнд шаардлагатай тавиурын тооцоог боловсруулан 4,0 сая төгрөгийн төсөл бичиж холбогдох газруудад санал болгоод байна.	70%
6.2	Улсын бүртгэлийн хэлтсийн барилга барих газрын асуудлыг шийдвэрлэх	Аймгийн Засаг даргын 2018 оны 04 сарын 12-ны өдрийн А/154 тоот захирамжаар 240 м <sup>2</sup> газрыг 30 жилийн хугацаатай конторын барилгын зориулалтаар тус хэлтэст эзэмшүүлсэн. Цахилгаан дулаанаар хангах байгууллагуудаас холбогдох зөвшөөрлийг авч зургийн компаниар тус хэлтсийн барилгын зураг төсвийг гүйцэтгүүлж эхлээд байна.	100%
<b>Долоо. Шүүхийн шинжилгээний чиглэлээр</b>			
7.1	Иргэдэд үзүүлэх үйлчилгээг ойр байхаар тооцож албаны барилгыг аймгийн төвд, бүх төрлийн инженерийн шугам сүлжээнд холбогдсон, байршил сайтай газарт шийдэж өгөх	Аймгийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/179 тоот захирамжаар 1000 мкв газрын конторын барилга барих зориулалтаар олгосон.	100%



7.2	Орчин үеийн шинэ дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжийг худалдан авахад дэмжлэг үзүүлэх	Аймгийн ГХУСАЗСЗ-өөс тус албаны үйл ажиллагааг хэвийн явуулах боломж нөхцлөөр хангахад зориулан Криминалистикийн хэсэгт шаардлага хангасан Epson L1800 A3 фото принтерийг олголоо. Тус албанд нэн шаардлагатай орчин үеийн шинэ дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжийн судалгааг гарган дээд шатны болон холбогдох газруудад хүргүүлээд байна.		70%
7.3	Папилон скайнер худалдан авах	“Адис-Папилан” станцын зориулалт бүхий чанарын шаардлага хангасан Папилон скайнерыг худалдан авах тооцоо судалгааг гаргасан хөрөнгө санхүүгийн боломж, дэмжлэгийг харгалзан 3, 4-р улиралд шийдвэрлэхээр боллоо. <b>(Хугацаа болоогүй)</b>	Х/Б	
<b>Найм. Гадаадын иргэн, харьяатын чиглэлээр</b>				
8.1	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.6 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллах	Тус аймаг хариуцсан Гадаадын иргэн харьяатын газрын төлөөлөл томилогдоогүй байгаа бөгөөд Гадаадын иргэн харьяатын газрын өмнөд бүс дэх газартай холбогдож шаардлагатай зөвлөмж дэмжлэг авч ажиллаж байна. тус аймгийн 15 суманд оршин суугаа гадаадын иргэдийн тоо, хаягийн бүртгэлийн мэдээг нэгтгэн тус газарт хүргүүлж хамтран ажиллаж байна. 2018 оны эхний хагас жилд тус аймагт гадаадын 5 улсын 164 иргэн буюу БНХАУ-ын 149(Сайнцагаан суманд 21, Дэрэн суманд 90, Гурвансайхан суманд 2, Эрдэнэдалай суманд 36) иргэн, АНУ –ын 7(Сайнцагаан суманд 3, Адаацаг суманд 1, Сайхан-Овоо суманд 1, Эрдэнэдалай суманд 1, Говь-Угтаал суманд 1) иргэн, Япон Улсын 3(Сайнцагаан суманд 3) иргэн, БНСУ-ын иргэн 4(Сайнцагаан суманд 4) иргэн, Финланд Улсын 1(Сайнцагаан усманд 1) иргэн оршин сууж байгаа талаар мэдээлэв. Дээрх иргэдийн үйл ажиллагаанд орон нутгийн удирдлага, Цагдаагийн байгууллагаас зохих хяналт тавьж байна.	100%	
<b>Ес. Хууль сахиулах салбарын хүний нөөцийг чадваржуулах, давтан сургах чиглэлээр</b>				
9.1	Аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарыг хамруулан аюулгүй байдлын “Стратегийн дамжаа”-ны сургалтыг хамтран зохион байгуулах	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан аюулгүй байдлын “Стратегийн дамжаа”-ны сургалтанд 2018 оны 6 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд хамрагдлаа.	100%	
<b>Арав. Хууль зүйн туслалцааны чиглэлээр</b>				

10.1	Тухайн орон нутгийн Засаг даргын зүгээс Хууль зүйн туслалцааны төвийн салбарын үйл ажиллагааг дэмжиж, шаардлагад нийцсэн ажлын өрөө, тасалгаагаар хангах, урсгал зардлыг хариуцах, интернетийн орчинг бүрдүүлэх	Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь төлөөлөгч нар орон тоогоор ажиллаж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Тус хоёр ажилтны ажиллах аймгийн Засаг даргын Тамгын өрөө, тасалгаагаар бүрэн эхний хагас жилд хууль зүйн иргэнд хууль зүйн болон туслалцаа үзүүллээ. Үүнээс холбогдогчтой 13 хэрэг, шүүхийн холбогдогчтой 1 хэргийг шүүхээр шийдвэрлэгдээгүй 4 холбогдогчтой хэрэг хүлээгдэж Хууль зүйн туслалцааны төвийн зүйн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх нь” нээлттэй хаалганы өдөрлөгт хуулийн байгууллагуудтай хамтран оролцож 20 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөхөөс гадна иргэдэд өргөдөл бичих үйлчилгээг үзүүллээ.		нь хэвийн явагдаж нөхцлийг ханган газарт ажлын хангасан.Тус оны зөвлөгөөг 145 өмгөөллийн шүүхээр 13 өмнөх шатанд 1 шийдвэрлэж, хэргийн 5 байна. өмгөөлөгч “Хууль өдөрлөгт хуулийн иргэдэд	100%
10.2	Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбарын архивын материалыг архивын тасагт хүлээлгэн өгөх боломжоор хангах	Тус төвийн 2016, 2017 оны архивын материалыг аймгийн Төрийн архивт хүлээлгэн өгөх боломжоор хангаж хамтран ажиллаж байна.	70%		
	Дундаж хувь		80.3%		

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

БИЕЛЭЛТИЙГ ТООЦОН ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ТҮВШИНБАЯР

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ